

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Р.Давааням*

Олон улсын хамтын ажиллагааны чухал нэг хэсэг нь эдийн засгийн хамтын ажиллагаа мөн. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох үйл явц үндэсний эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх, өөрийн нөөц бололцоонд тулгуурлан брэнд бүтээгдэхүүнийг бий болгох дагнаж үйлдвэрлэснээр өртөг буурах, үйлдвэрлэлийг төрөлжүүлснээр хөдөлмөрийн бүтээмж сайжрахаас гадна бусад хамтын ажиллагаатай орнуудын зах зээлд гаргах, худалдааны хөнгөлөлтүүдийг эдлэх, өрсөлдөх чадвар сайжрах зэрэг давуу талуудыг бий болгодог.

Тухайн улс орон гадаад худалдааныхаа голлох хэсгийг хөрш зэргэлдээ болон эдийн засгийн хамтын ажиллагаатай орнуудтай хийх хандлагатай байдаг. Энэ нь бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах, худалдах, тээвэрлэх зэрэг холбогдох зардал бага байхаас гадна үйлдвэрлэгч нь бүс нутаг, хамтын ажиллагаатай орнуудын эрэлт, хэрэгцээ, хэрэглэгчдийн шаардлагыг илүү сайн мэддэг, мэдэрдэгтэй холбоотой.

Хамтын ажиллагааны ашиг тусын тухайд

Улс орнуудын хамтын ажиллагааны “амин сүнс” нь хамтын ажиллагааны харилцан ашигтай механизмыг бүрдүүлэх явдал юм. Олон улс, бүс нутгийн хамтын ажиллагааны механизм бий болох нь дараах ашиг тустай байдаг. Жишээ нь:

- ✓ Иргэд хоорондын хамтын ажиллагаа сайжрах
- ✓ Бүтээгдэхүүний сонголт нэмэгдэх, үнэ багасах, чанар нэмэгдэх
- ✓ Бизнесийн төлөвлөлт сайжрах
- ✓ Зах зээл нээлттэй болох, шинэ санал санаачилагаар өрсөлдөх, таавар бүтээгдэхүүний үнэ багасах зэрэг юм.

Эдийн засгийн төлөв байдлын хувьд:

Энэ хүрээнд худалдаа өсөх, бүс нутгийн хамтын ажиллагааны үр дүнд эдийн засгийн хөгжил хурдасдаг бөгөөд хамгийн гол үр дүн нь худалдааг чөлөөтэй болгох явдал юм. Худалдааг чөлөөтэй болгосноор:

- Иргэдийн ахуй амьдралын чанар дээшилж бага үнээр илүү сонголт сайтай бүтээгдэхүүнээр хэрэглээгээ нэмэгдүүлэх боломжтой.

*ШУА-ийн ОУСХ-ийн ЭША

▪ Бизнесийн нөхцөл байдлын тухайд шинэ зах зээл нээгдэнэ, шинэлэг санал санаачлага нэмэгдэнэ, өрсөлдөөн ихсэнэ, хоорондоо хэлэлцэн тохирсон байдлаар бүтээгдэхүүний үнэ тогтоох байдал багасна.

▪ Улс орнуудын эдийн засаг хоорондын харилцаа, харилцан ашигтай худалдаа эрс нэмэгдэнэ. Үүний үр дүнд бүс нутгийн эдийн засгийн урт хугацааны хөгжлийн нөхцөл байдал хадгалагдах зэрэг ач холбогдолтой.

XXI зуунд тухайн улс орон бүхэн өөрийн давуу тал, нөөц боломжоо зөв ашиглан өөрийн бүтээгдэхүүнүүдийг бий болгох, түүгээрээ бүс нутаг, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжийг эрэлхийлж байна. Шинэ тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дагнах буюу хамтран ажиллах нь эдийн засгийн хувьд илүү үр ашигтай байдаг нь нэгэнт тодорхой болсон.

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь зөвхөн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг урагшлуулахад дөхөм болоод зогсохгүй, дэлхийн дахины бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааг өсгөн нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц өгдөг. Өөрөөр хэлбэл бүс нутгуудын эдийн засгийн бүлэглэлүүд нь дэлхийн эдийн засгийн хөгжилд, худалдаанд голлох үүрэг гүйцэтгэдэг. Тэгэхээр бүс нутгийн хамтын ажиллагаа /интеграци/ нь өөрөө дэлхийн эдийн засгийн интеграцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн өөрчлөн байгуулагч үйл явц юм.¹

Өнөөдөр интеграцчилагдсан нэгдлүүдийн гол төлөөлөл нь бүс нутгуудын хамтын ажиллагаа юм. Тэгэхдээ бүс нутгийн интеграцилал нь олон үе шатыг давж бий болдог бөгөөд үе шат бүр нь өөрийн гэсэн онцлогтой. Мөн тухайн үе шат бүрт тодорхой саадуудыг арилган улс орнууд хоорондын үр ашигтай гадаад эдийн засгийн харилцаанд зориулагдсан урьдчилсан нөхцлүүдийг яриа хэлэлцээрээр бий болгодог. Үүний үр дүнд нийт улс үндэстнүүд болон улс орнууд хоорондын хамтын удирдах байгууллага, яриа хэлэлцээрт уялдсан бүс нутгийн эдийн засгийн бүхэл бүтэн цогц үйл ажиллагаа явагдаж байдаг.²

Зүүн хойт Азийн бүс нутгийн тухайд

Зүүн хойт Азийн бүс нутгийн хувьд хамтын ажиллагааны механизм төдийлөн үр дүнтэй хөгжөөгүй байна. Энэ нь бүс нутгийн улс орнууд улс төр, эдийн засгийн өөр өөр системд харьяалагдаж, бие биеэсээ ялгаатай үзэл суртал баримтлаж, дэлхийн бусад орнуудтай харилцах асуудалд харилцан адилгүй байр суурьтай байдаг.³

1. Б.Балдоо “Ази номхон далай ба зүүн хойт азийн бүс нутгийн хамтын ажиллагааны хөгжлийн үйл явц” Монгол улс ба зүүн хойт ази УБ. 2002. 9 тал

2. “Олон улсын эдийн засгийн харилцаа” УБ.2005. 301 тал

3. Ерөнхийлөгчийн, парламентийн засаглал, нэг нам болон олон намын систем, төрөөс ихээхэн хамааралтай болон чөлөөт эдийн засгийн тогтолцоог хөгжүүлж байгаа гэх мэт

Зүүн хойт Азийн энэхүү өргөн уудам нутгын хувьд өөрийн өвөрмөц онцлогтой. Хүн ам ихтэй, байгалийн нөөцөөр баян, соёлын үнэт чухал өв уламжлалтай юм. Тус бүс нутагт БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, Монгол зэрэг улс орон багтдаг. Зүүн хойт Ази /ЗХА/-д дэлхийн томд тооцогдох дөрвөн эдийн засаг, НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүний 3 нь оршин байдаг. ЗХА-д эдийн засгийн хамтын ажиллагаа нь хоёр болон гурван орны /талт/ хооронд голлон өрнөж байгаа, бүс нутгийн хэмжээнд өргөн хүрээтэй байнгын ажиллагаатай байгууллаг одоогоор бүрэлдээгүй бүрэлдэх эхэн шатандаа буюу хэлэлцээр хийх шатандаа байна⁴. Бүс нутгийн онцлог байдлыг авч үзвэл:

✓ ЗХА-ийг соёл талаас нь авч үзвэл үндэстэн шашны хувьд эдгээр орнууд өөр өөр юм. Тухайлбал: үнэн алдартны шашны төв болох ОХУ, Кунзын сургаал, соёл голлосон БНХАУ, Христ болон Буддын шашинтай БНСУ /Христийн шашинтай 29.2 хувь, Буддын шашинтай 22,8 хувь, Буддын болон Шинто шүтлэгтэй Япон мөн Буддын шашны томоохон төлөөлөл болсон Монгол зэрэг орнууд тус тус хамаарна.

✓ Хоорондын зөрчилтэй асуудлуудын хувьд ОХУ-Япон улсуудын хооронд Курилын арлуудын, ОХУ-Хятад Амур мөрний сав газрын, Солонгосын хойг хилийн шугамын, Хятад-Тайваний улс төрийн, Хятад-Япон Дорнод Хятадын тэнгис орших Сенкаку арлын зэрэг газар нутгийн маргаантай байдаг.

✓ Эдийн засгийн хувьд тус бүс нутагт дэлхийн 2, 3 /БНХАУ, Япон/ дахь эдийн засаг, эрчимтэй хөгжиж буй БНСУ, ОХУ, байгалийн нөөц ихтэй улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг хийж буй Монгол зэрэг улсуудаас бүрддэг.

Зүүн хойт Азийн хамтын ажиллагааны ерөнхий хандлага

XXI зууны эхэнд даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж, улс хоорондын харилцаа, олон талт хамтын ажиллагааны цар хүрээ улам бүр тэлэн өргөжиж байна. Энэ үйл явц дэлхий нийтийн шинж чанартай болж улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг-стратегийн зэрэг бүхий л салбарыг хамарч, улс хоорондын харилцааг өөр хоорондоо нягт уялдаатай, ихээхэн түгээмэл агуулгатай болгож байна.⁵

Бүс нутаг нь геополитик, өндөр технологи, капитал, ноу-хау болон хөдөлмөрлөх ажиллах хүчний болон байгалийн баялагын хувьд харилцан орлох асар их чадавхитай боловч тэдгээр нь бусад бүс нутгийн

4. Зүүн Азийн эдийн засгийн хөгжлийн үндэс нь хамтын ажиллагаа - <http://economy.time.mn/content/7993.shtml#sthash.TWeCgyoR.dpuf>

5. Зүүн Хойд Азийн энх тайван, аюулгүй байдлын хамтын ажиллагааны зарим асуудал: Монгол Улсын хүчин чармайлт” <http://mongoliaworld.net/2011/11/24/>

байгууллагуудтай⁶ адил түвшинд харилцан ашигтай өндөр үр дүнтэйгээр хамтаар ашиглаж чадахгүй хараахан чадаагүй хэвээр байна. Эдгээр чадавхийг бүрэн дүүрэн, үр дүнтэй ашиглах, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагыг бий болгож харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь тус бүс нутгийг дэлхийд нөлөө бүхий эдийн засгийн хамтын ажиллагааны байр сууринд хүргэх боломжтой юм.⁷

Нөгөө талаас Европ тив дэх бүс нутгийн байгууллага /Европын холбоо/ Зүүн Өмнөд Азийн хамтын ажиллагааны байгууллага /АСЕАН/ зэрэг байгууллагатай энэ зэрэгцэх бүс нутагт өнөө хир Зүүн хойт азид бүрэлдээгүй байна. Одоогоор тус бүс нутагт ойртон нягтрах, түүний дотор хамтын аюулгүй байдлын нийтлэг зүйлийг бий болгох чармайлт ид явагдаж байна. Хэрэв Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудлыг эс тооцвол бол Зүүн Хойд Азид олон улсын аюулгүй байдал огцом хүндрэх, томоохон зөрчил сөргөлдөөн үүсэх магадлал бага байна. Одоогоор энэ бүс нутгийн орнууд АНУ-ын оролцоотойгоор Солонгосын хойгийн зөрчил, маргаантай асуудлыг 6 талт хэлэлцээрийн замаар шийдвэрлэх, улс төр, эдийн засгийн салбарт ойртон нягтрах, түүний дотор хамтын аюулгүй байдлын нийтлэг зүйлийг бий болгохыг чармайж байна.

Монгол Улсыг хүрээлсэн орон зайд “Хүйтэн дайн”-аас хойш гарсан эрс өөрчлөлт, хөгжлийн цаашдын хандлага нь биднийг ирээдүйн хөгжил, аюулгүй байдлын асуудлаа Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн Азийн хүрээнд АНУ-тай идэвхитэй түншлэх бодлогод тулгуурлан авч үзэхэд хүргэж байна.

Монгол Улс гадаад худалдааныхаа дийлэнх хувийг хөрш зэргэлдээ болон бүс нутгийн орнуудтай хийдэг. Энэ тохиолдолд бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргаж худалдаалах тээврийн болон бусад зардал бага байхаас гадна үйлдвэрлэгч нь бүс нутгийнхаа хэрэгцээ, шаардлагыг илүү сайн мэдэрдэгтэй холбоотой. Мөн бүс нутгийн улсууд байгаль цаг агаарын нөхцөл, зан заншил, хэрэглээний соёл ойролцоо байх тул бүтээгдэхүүнд тавигдах нэмэлт шаардлага бага юм.⁸ Бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааны хэд хэдэн механизмуудыг бий болгох хүчин чармайлтыг гаргасаар ирсэн. Тухайлбал Түмэн гол нутгий хөгжлийн хөтөлбөр, Гурван талт хамтын ажиллагаа, Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт зэрэг хамтын ажиллагааны механизмууд юм.

Түмэн гол нутгийн хөгжлийн хөтөлбөрийн тухай

Түмэн голын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх тухай үзэл санааг анх Чанцуны бага хурлаас⁹ гарган тавьсан. Тус үзэл санааг бүс нутгийн улс

6. Европын Холбоо, АСЕАН гэх мэт

7. Л.Нямцэрэн “Шинэ эриний сорилт: Монголын хөгжлийн хүчин зүйлс” УБ. 2007. 171 тал

8. Б.Санжмятав “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт. УБ, 2006. 14 тал

9. АНУ-ын Гавайн арал дахь Гонолулу хотын Дорно-Өрнө төв болон БНХАУ-ын Ази номхон

орнууд хамтын ажиллагааны эхлэл гэж үзэж, таатай хүлээн авч, цаашлаад НҮБ-ын 20-р хурлын ивээн тэтгэлэгт, идэвхи санаачлага гаргасан байдаг.

1991 оны 7 сард Улаанбаатар хотод НҮБ-ын 20 чуулганаас ивээн тэтгэсэн бүс нутгийн уулзалт болсон. Тус уулзалтад БНХАУ, БНСУ, БНАСАУ, МУ-ын төлөөлөгчид оролцож байсан. Харин 1991 оны 10-р сард БНАСАУ-ын нийслэл Пхеньян хотод бүс нутгийн орнуудын уулзалт болж НҮБ-ын шинжээчдийн хийсэн судалгааны тайланг хэлэлцэж хөтөлбөрийн төслийн талаар тохиролцож гарын үсэг зурсан бөгөөд 1992 онд ЗХУ тус хөтөлбөрт нэгдсэн орсон. Уг хөтөлбөрийн гол санаа нь Түмэн голын сав газарт аж үйлдвэр, зам тээвэр, холбоо харилцаа, санхүүгийн үйл ажиллагааг явуулах шинэ төвийг бий болгоход чиглэж байсан. Тус төслийг “Түмэн голын хөгжлийн хөтөлбөр” (Tumen river area development program) гэж нэрлэж байсан.

Тус төслийн хүрээнд тавьсан гол санаа нь Түмэн голын сав газарт аж үйлдвэр, зам, тээвэр, холбоо харилцаа, санхүүгийн үйл ажиллагааг явуулах шинэ төвийг бий болгоход оршиж байсан. Төслийг “Түмэн гол нутгийн хөгжлийн хөтөлбөр”/ТГНХХ/ Tumen River Area Development Programme –TRADP/ гэж нэрлэв.¹⁰

Монгол улсын хувьд дээрхи төсөлд эхнээс нь идэвхитэй оролцож ирсэн. МУЗГ-ын 1995 оны 5 сарын 24-ний хуралдаанаар Түмэн бүсийн хөтөлбөрт оролцох эсэх талаар авч хэлэлцэж баримтлах бодлого чиглэлээ тодорхойлж байсан. Манай улс Дорнод Монголыг Зүүн Хойт Хятадаар дамжуулан Түмэн голын хөтөлбөрт холбогдох, улмаар түүнийг түмэн голын бүсгийн нэг төв болгон хөгжүүлэх чиглэлийг баримталж байсан.¹¹

Хөтөлбөрийн хүрээд хамтын ажиллагааны дагуу Монгол, Хятадаас эхтэй шар шороон шуурга Азийн бусад улсууд тэр дундаа БНАСАУ, БНСУ, Япон зэрэг улсуудын иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх болсонтой холбогдуулж 2004 оноос Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр тус үйл явцыг зогсоох төслийг хэрэгжүүлснээс гадна ЗХА-ийн улсуудын эрчим хүчний хэрэглээг хангах хүрээнд ОХУ-ын зүүн бүсийн эрчим хүчний ихээхэн нөөцийг Монгол улсаар дамжуулан ЗХА-ийн орнууд руу гаргах гарцыг бий болгоход Монгол улс болон ЗХА орнууд идэвхитэй ажиллаж, 2001 онд эрчим хүчний экспертүүдийн уулзалтыг ОХУ-ын Хабаровск хотноо, 2003 оны 4 сард Владивосток хотноо, 2004 онд Тайландын нийслэл Бангкок хотноо ЗХА орнуудын зөвлөлдөх уулзалтуудад идэвхи

далайн хүрээлэнтэй хамтран Чанчуны бага хурлыг зохион байгуулсан тус хурлаар Түмэн голын сав газрын тусгайлан авч үзэж Зүүн хойт, баруун хойт Хятад, Оросын Дорнод Сибирь ба алс дорнодын газар нутаг, Өмнөд болон Умард солонгос, Япон, Монгол улсуудыг оруулж хамтын ажиллагааны механизмийг бий болгох үзэл санааг анх гаргасан.

10. Б.Балдоо “Зүүн хойт азийн бүс нутагчилан хөгжүүлэхийн төлөө үйл ажиллааны өнөөгийн байдал” Монгол Улс ба зүүн хойт ази. УБ.2002. 53 тал

11. Б.Санжмятов “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт УБ.2006. 199 тал

санаачлагатай оролцож байсан. Мөн дэд бүтэц, авто зам, бүс нутгийн худалдаа болон чөлөөт бүс байгуулах санал санаачлагыг идэвхитэй дэмжин ажилласаар ирсэн.

Бүс нутгийн улсуудын хамтын ажиллагаа: БНХАУ, Япон, БНСУ-ын гурван талт харилцаа

Зүүн Хойт Азийн бүс нутаг дахь интеграци нь бүс нутгийн улс орнуудын хүрээнд гэхээсээ БНХАУ, БНСУ, Япон улсуудын гурван талт хамтын ажиллагааны хүрээнд идэвхитэй яригдаж, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хүчин чармайлт гаргаж байна. Тус хамтын ажиллагааны гол зорилго нь чөлөөт худалдааны бүс байгуулах явдал юм. Чөлөөт худалдааны гэрээг тус улсууд ОХУ-БНХАУ, БНХАУ-БНСУ гэх мэтээр 2 улсууд хоорондын худалдааг өрөгжүүлэх зорилгоор хийж ирсэн бөгөөд өнөөдөр 3 улсыг харуулсан өргөн хүрээтэй чөлөөт худалдааны гэрээг хийх яриа хэлэлцээрийг хийж эхнээсээ ажил хэрэг болж байна.

Гурван орны тэргүүн нарын гурван талт хамтын ажиллагаа хөгжүүлэх анхны албан бус уулзалтаас хамтын ажиллагаа нь төр, засгийн болон сайд нарын, ахлах албан тушаалтны гэсэн түвшинд ажиллаж хэвшжээ. Тус 3 улсын хамтын ажиллагааны үндсэн чиглэл нь худалдаа, хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх, нэмэгдүүлэх таатай орчинг бүрдүүлэх, сайд нарын болон яамдын хоорондын яриа, гэрээ хэлэлцээрийг эрчимжүүлэх, зам тээвэр, дэд бүтцийн чиглэлээр хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх 2 буюу БНХАУ ба Япон, Япон ба БНСУ, БНСУ ба БНХАУ гэсэн чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэхээс гадна Хил, гаалийн салбарт харилцан туслалцааг 3 улсын хүрээнд үзүүлэх, хорио цээрийн салбарт халдварт өвчин болон хүнсний аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийг байгуулан ажиллаж байна.

Гурван улсын хамтын ажиллагаа нь төр засгийн тэргүүн нарын 1999 онд болсон анхны албан бус уулзалтаас эхэлсэн. 2003 оны 10 сард Балид болсон гурван улсын төр, засгийн тэргүүн нарын уулзалтаас Хамтарсан тунхаглал гаргаж, хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ хил дамнасан буюу ирээдүй рүү хандсан хамтын ажиллагаанд илүү анхаарч дэмжих, эдийн засаг, худалдаа хөрөнгө оруулалт, санхүү, аялал жуучлал, улс төр, аюулгүй байдал, соёл мэдээлэл болон холбооны технологийн салбарт тэргүүн ээлжинд хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар тохиролцож, 3 талт хамтын ажиллагаа өрнөж байсан.

Өнөөдөр дэлхийн эдийн засгийн салхи өрнөөс дорно зүгт чиглээд буй энэ үед дэлхийн эдийн засагт нөлөөлөх Зүүн Хойд Азийн хүчийг нэмэгдүүлэхээр БНХАУ, Япон болон БНСУ гурван улс тун удахгүй гурван талт чөлөөт худалдааны гэрээ байгуулахаар болсон тухай 2012 оны 5 сард болсон гурван улсын дээд хэмжээний уулзалтын дараа БНХАУ-ын

Ерөнхий сайд Вэн Жя Бао мэдэгдсэн. Дээрх гурван улсын тухайд бүгд дэлхийн худалдаанд томоохон байр суурь эзлдэг, хамтдаа дэлхийн эдийн засгийн 19.6 хувийг бүрдүүлдэг, экспортын 18,5 хувийг дангаараа эзэлж байна.

Бүс нутгийн тэргүүлэх улсууд болох Япон, БНХАУ, БНСУ-уудын харилцаа хэдий эрчимтэй явагдаж буй боловч өнөөг хүртэл Зүүн Хойт Азийн бүс нутгийн хэмжээнд бүс нутгийн байгууллага бүрэлдэн бий болоогүй байсаар байгаа бөгөөд олон талт үзэл санааг бий болгох чиглэлээр хийгдэж буй 6 талт хэлэлцээр эдүгээ ээдрээтэй, зогсонги байдалд ороод байна.¹² Мөн бүс нутгийн орнуудын дунд зөрчил маргаан байсаар байна. Япончууд, Өмнөд Солонгосчуудын хувьд газар нутгийн маргаан, мөн Хятадын цэргийн стратегийн талаарх болгоомжлол нь эдийн засгийн шинэ холбоог байгуулахад сөргөөр нөлөөлж магадгүй гэдгийг ОХУ-ын олон улсын тоймч В.Скосырев тэмдэглэсэн байдаг.

Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт

Тээвэр, харилцаа холбооны техник технологийн дэвшил, улс төрийн хурцадмал байдал намжсан зэргээс үүдэн улс хоорондын харилцаа илүү олон талтай, идэвхитэй болж байгаа билээ. Өнөөдөр ямар ч улс бусад бүс нутаг, улс орнуудтай улам ойртож харилцахгүйгээр үндэсний өрсөлдөх чадвар, бүс нутгийн хөгжлийг дэмжиж тэтгэж чадахгүй.

Дэлхийн шинэ дэг журам “зөрчил мөргөлдөөнөөс найрамдал, хамтын ажиллагаа”-нд шилжиж байна. Үүний нэг илрэл нь Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт юм. Тус байгууллагын зорилго нь байгууллагын гишүүн орнуудын хоорондын харилцааг илүү нээлттэй болгох, хамтын ажиллагааг нягтруулах, үр дүнг нь дээшлүүлэхэд чиглэж байна.

Бүс нутгийн нэгдэл

Хятад, Монгол, Хойд Солонгос, ОХУ зэрэг орнууд нь өдгөө хязгааргүй нөөц бололцоотой хэмээн тооцогдож байгаа бол АСЕАН болон Зүүн Өмнөд Азийн орнуудын ажиллах хүч, цаг агаарын таатай байдал, зам тээвэр, усан болон агаарын тээврийн зангилаа газар зүйн байршил, АНУ, Япон, БНСУ зэрэг техник технологи өндөр хөгжсөн улсуудын технологийн дэвшил зэргийг ашиглан Зүүн Ази нь цаашдаа дэлхийн эдийн засгийн гол төв болох хандлага ажиглагдаж байна.

12. Ж.Баттөр “Зүүн азийн орнуудын зөрчил, маргаан: сорилт ба боломжууд” УБ.2011. Монгол Улсын их сургууль, Олон Улсын харилцааны сургуулийн эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. 173 тал

ЗҮҮН АЗИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ



*Дэлхийн хүн амын 56 хувь

*АСЕАН гишүүн орнууд

*Дэлхийн нийт бүтээгдэхүүний 55 хувь

Хамтын ажиллагаа

XXI зуунд цаг үеийн өөрчлөлттэй уялдаж хамтдаа хөгжихийн тулд, Зүүн Азийн Бүс нутагт харилцаа, хамтын ажиллагааны механизм болох бүсийн хэмжээний улс хоорондын байгууллага байгуулах шаардлагатай юм.

Зүүн Азийн Бүс нутгийн орон зайд эрх ашиг, соёл, улс төрийн болон эдийн засгийн олон асуудлаас үүдэж хамтын ажиллагааны механизм нь төдийлөн үр дүнтэй болж чадахгүй байна. Бүс нутгийн хамтын ажиллагааны үр дүнтэй хамтын ажиллагаа өрнөж буй Зүүн Өмнөд Ази буюу АСЕАН-ны хамтын ажиллагааны байгууллагыг түшиглэн түүн рүү чиглэсэн хамтын ажиллагааны механизм илүүтэй үр дүнтэй хөгжиж байна. Энэхүү хамтын ажиллагааны механизм нь Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт (East Asian Summit) юм.

Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт (EAS) нь чуулга уулзалт хэлбэрээр Ази номхон далайн бүс нутгийн 16 улсын тэргүүлэгчид оролцдог. Дээд хэмжээний уулзалтаар эрчим хүчний аюулгүй байдал, худалдааны асуудлыг голлон хэлэлцэж ирсэн юм. Дээд хэмжээний уулзалтын гишүүд нь АСЕАН-ны 10 гишүүн улсууд, АСЕАН+8 БНХАУ, Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг, Австрали, Шинэ Зеланд, ОХУ, АНУ юм. Эдгээр улсуудад дэлхийн хүн амын дийлэнх хувь амьдарч байна. Анхны дээд хэмжээний уулзалт нь 2005 оны 12 сарын 14-нд Малайз улсын Куала Лумпур хотноо болсон.¹³

13. "East Asia Summit" http://en.wikipedia.org/wiki/East_Asia_Summit

Зүүн Азийн дээд хэмжээний уулзалтыг үүсгэн байгуулах санааг 1991 онд Малайз улсын ерөнхий сайд Махатир Бин Мохамад гаргаж байсан бөгөөд 2002 оны АСЕАН нэмэх гурван буюу БНСУ, БНХАУ, Японы хамтарсан уулзалтаар Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт хамтын ажиллагааны механизмыг байгуулахаар тогтож, АСЕАН нэмэх 3 буюу Япон, БНСУ, БНХАУ-ууд дээр Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг улсуудыг гишүүнээр элсүүлсэн. Тус хамтын ажиллагааны механизм нь АСЕАН болон Энэтхэг, БНХАУ, БНСУ, Япон улсууд, Номхон далайн орнууд болох Шинэ Зеланд, Австрали улсуудыг эгнээндээ нэгтгэсэн Ази Номхон далайн орнуудыг хамарсан эдийн засгийн хамтын ажиллагааны томоохон байгууллага байсан бол 2011 онд Дэлхийн улс төр, эдийн засгийн жин нөлөө бүхий АНУ, ОХУ гишүүнээр элссэн.

АНУ-ыг гишүүнээр элсэхийг Япон, БНСУ харин ОХУ-ыг гишүүнээр элсэхийг БНХАУ, Энэтхэг улсууд идэвхитэй дэмжиж байв. Тус хамтын ажиллагааны байгууллага нь нийт 18 орныг эгнээндээ нэгтгэсэн улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны томоохон механизм болж төлөвшиж байна.

Дээд хэмжээний уулзалтын он дараалал¹⁴

Уулзалт	Орон	Он сар	Уулзалтын онцлог
1 дэх уулзалт	Малайз, Куала Лумпур	2005/11/14	Тус дээд хэмжээний уулзалтыг үүсгэн байгуулсан
2 дахь уулзалт	Филиппин, Себу	2007/1/15	Себугийн тунхаглал, Зүүн Азийн эрчим хүчний аюулгүй байдал
3 дэх уулзалт	Сингапур	2007/11/21	Сингапурын тунхаглал, Цаг уурын өөрчлөлт ба хүрээлэн буй орчин
4 дэх уулзалт	Тайланд	2009/10/25, 10 сарын 25, 2009	Уулзах газрын байршил, огноогоо хэд хэдэн удаа өөрчилсөн. Дээд хэмжээний уулзалт Паттаяд 2009.04.12 болохоор төвлөсөн ба Тайланд уулзах газраа эсэргүүцэгчдийн тэмцлээс болж цуцалжээ. Дээд хэмжээний уулзалтыг Пукетаас Ча Ам, Хуа Хин-руу дахин шилжүүлж 2009.10 сарын товгыг өөрчилсөн.
5 дахь уулзалт	Вьетнам, Ха Ной	10 сарын 30, 2010	АНУ болон ОХУ- гишүүнээр элсэх хүсэлт гаргасан.
6 дахь уулзалт	Индонез, Бали	11 сарын 19, 2011	АНУ болон ОХУ тус дээд хэмжээний уулзалтын гишүүнээр элссэн.
7 дахь уулзалт	Камбожи, Пном Пен	11 сарын 20, 2012	Зүүн Хятадын далай дахь газар нутгийн зарим маргаантай асуудал /Сенкаку, Диаю арлын асуудал / гишүүн орнуудын хоорондын эдийн засаг, худалдаанд нөлөөлж болзошгүй байдлыг хэлэлцсэн

14. “Meetings held” http://en.wikipedia.org/wiki/East_Asia_Summit

Хамтын ажиллагааны үзэл санаа


Зүүн Азийн тэргүүнүүд удахгүй дэлхийн хамгийн өргөн хэмжээний худалдааны гэрээг байгуулахыг зорьж байна. Үүнд нь 16 улсуудын 16,7 трилион дотоодын нийт бүтээгдэхүүн ойролцоогоор 3 тэрбум хүн оролцохоор юм. Тус чөлөөт худалдааны гэрээг байгуулах үйл явц сүүлийн 2 жилийн турш яригдаж Австрали, БНХАУ, Энэтхэг, Япон, БНСУ, Шинэ Зеланд улсууд чөлөөт худалдааны гэрээг АСЕАН-тай байгуулсан буюу бйагуулахаар зорьж байна. Харин Зүүн Азийн дээд хэмжээний уулзалтын бусад гишүүн орнууд болох ОХУ, АНУ одоогоор тус чөлөөт худалдааны гэрээг байгуулах үйл ажиллагаанд багтаагүй. Австрали улс тус чөлөөт худалдааны хэлэлцээрт АНУ-ыг нэгдэн орохыг дэмжсэн байр суурьтай байдаг.

Түүнчлэн АСЕАН-ны гишүүн Вьетнам, Сингапур болон Малайз зэрэг орнууд Зүүн Азийн чөлөөт худалдааны гэрээг байгуулах санаачилгыг дэмжиж байгаа бол үлдсэн орнууд тус чөлөөт худалдааны бүс байгуулах үйл явцыг хэтдээ бүдгэрнэ гэж үзэх үзэл ч байна. Тухайлбал: Сингапурын худалдааны сайд Лим Хн Кин хэлэхдээ 2 хэлбэрийн түншлэлийн зорилго нь нэг болохоороо удаан хугацааны дараа зөвхөн нэг хэлбэрийн замнал буюу Ази Номхон далайн чөлөөт худалдааны хэлэлцээрийг бий болгох болно гэж тэмдэглэсэн, Худалдааны сайд Цанг Эмерсон тэрээр “Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь нэгэн харгуй жимээр Ази болон Номхон далайн чөлөөт худалдааны орчин гэсэн оргил руу тэмүүлж байна бид тэрхүү хэлэлцээрийг удахгүй байгуулж чадна” гэж хэлсэн нь бас байна.

Дээд хэмжээний уулзалтын үйл ажиллагаа нь тогтмолжиж, гишүүнчлэлийн хүрээ нэмэгдэх нь бүс нутгийн нэр нөлөөг дэлхийн тавцанд улам нэмэгдүүлж байна. Цаашид илүү үр дүнтэй хамтын ажиллагаа өрнүүлэх бүрэн боломжтойг судлаачид тэмдэглэж байна.

Зураг 2

Бүс нутгуудийн хөгжил



Тус байгууллагад Зүүн хойт Азийн орнуудаас Монгол Улс ганцаар гишүүнээр элсээгүй. Монгол Улс нь газар зүйн байршил, байгалийн баялаг, эдийн засгийн өсөлтийн хувь зэргээрээ бүс нутгийн төдийгүй дэлхийн хэмжээнд анхаарал татсан улсын хувьд тус хамтын ажиллагааны механизмийн гишүүн орон болох нь манай улсын эдийн засгийн хөгжилд тодорхой үр дүнг бий болгох бололцоотой юм.

Дүгнэлт

Зүүн Хойт Ази бүс нутгийн хэмжээнд тулгамдсан асуудлууд болох эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй болгох, Өмнөд Хятадын тэнгист улс орнуудын ашиг сонирхол газар нутгийн маргааныг хойш тавин бүс нутгийн хэмжээний үр дүнтэй хамтын ажиллагааг өрнүүлж чадахуйц механизмыг бий болгох үйл ажиллагаа Түмэн гол төсөл, Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт зэргээр хэрэгжиж байна. Зүүн Хойт Азийн хамтын ажиллагааны механизмыг бий болгоход олон саад бэрхшээлийг туулж, өнөөдрийг хүрч байгаа боловч багагүй амжилтад хүрээд байна.

Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт нь тогтмолжиж, дан ганц эдийн засгийн утгаас гадна бүс нутгийн хэмжээнд зайлшгүй шийдвэрлэвэл зохих байгаль, цаг уур, хүрээлэн буй орчин цаашлаад улс хоорондын үл ойлголцох асуудлуудыг шийдвэрлэх гол хөшүүрэг, арга зам болж хэлбэржиж байна. Үүний гол илрэл нь дээд хэмжээний уулзалтын хүрээнд хийгдэж буй салбаруудын сайд нарын уулзалт түүнээс гаргаж буй албан бичгүүд болж байна.

Цаашдаа тус байгууллага нь дан ганц Зүүн Азийн бүсийн байгууллага болж үйл ажиллагаагаа явуулаад зогсохгүй, дэлхийн эдийн засаг улс төрийн үйл явцад нөлөөлөхүйц хамтын ажиллагааны механизм болж өргөжих төлөвтэй байна. Тухайлбал дэлхийн эдийн засаг, улс төрийн нөлөө бүхий Евро Азийн улс болох ОХУ, Америк тивийн улс, АНУ-ууд тус хамтын ажиллагааны механизмд гишүүнээр элсээд байгаа нь үүний гол илрэл бөгөөд Зүүн Азийн бүсийн олон улсуудтай холбоотны харилцаатай АНУ эхлээд Зүүн Азийн дээд хэмжээний уулзалтад нэгдэхийг сонирхохгүй байсан боловч сүүлийн жилүүдэд байдал өөрчлөгдсөн. Хятадын эдийн засгийн хүчирхэг өсөлт, тус орны үр нөлөө бүс нутагт өргөжсөн явдал Зүүн Азийн орнуудыг болгоомжлоход хүргэв. Энэ нь нөгөө талаар улам өсөн нэмэгдэж буй Хятадын сүр хүчийг тогтоон барихад олон улсын хэлэлцээрийн индрийг оролцуулан бүх боломжийг ашиглах гэсэн АНУ-ын хүсэл эрмэлзэлд нийцэж байна. Барак Обама Ерөнхийлөгч болсноос хойш АНУ-аас Зүүн Азид хийсэн дипломат арга хэмжээний нэг илрэл юм.

Харин эрчим хүчний нөөцөөр баялаг болон газрын тос, хийн аж үйлдвэр, цахилгаан эрчим хүч, атомыг энх тайваны зорилгоор ашиглах салбарт тэргүүний технологитой Орос улс бүс нутгийн эрчим хүчний аюулгүй байдалд багагүй хувь нэмрээ оруулах боломжтой юм.

ОХУ-аас санал болгосон Солонгосын хойгт хэрэгжүүлэх эрчим хүч, дэд бүтцийн төслүүд мөн хойгийн түгшүүртэй байдлыг нэлээд намжааж мэднэ. Үүнээс харвал дэлхийн нөлөө бүхий улс орнууд тус байгууллагын үйл ажиллагаанд оролцож байгаа нь тус хамтын ажиллагааны механизмын жин нөлөөг өсгөж байна.

Зүүн Азийн хамтын ажиллагааны гол зорилго нь харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчим юм. Энэхүү зарчмын гол санаа нь хүч хэрэглэхээс татгалзах, улс орнуудын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх бөгөөд мөн тус бүс нутгийн улсуудын угсаатны болон соёлын олон хэлбэрийг хүлээн зөвшөөрөхөд чиглэгдсэн.

Улс орнууд дэлхийг хамарсан хямралыг даван туулах, өөрсдийн хүч бололцоог үүнд зохицуулан тааруулах, идэвхитэй хамтран ажиллах түүхэн шаардлага тулгарч байна. Шинжлэх ухаан, технологийн хурдтай хөгжил, даяаршлын үйл явцын нөлөөгөөр улс орнуудын газар зүйн байршил, хэл, соёл, уламжлал, зан заншил болон эдийн засаг нэгэн цогц болж, хөрөнгө оруулалт, худалдааны хамтын ажиллагаа тасралтгүй хөгжиж буй энэ үед Монгол улс Зүүн Азийн орнуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийг гадаад бодлогын тэргүүлэх зорилт болгосон хэвээр байна.

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн 149 орноос хамтын ажиллагааны механизмд нэгдэх тал дээр идэвхи сул оролцоотой улсын тоонд багтаж байна. Монгол Улс одоогоор бүс нутагт явагдаж байгаа худалдаа, эдийн засгийн интеграцичилалд оролцох оролцоо сул байгааг яаралтай өөрчлөх нь манай гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тэргүүлэх зорилт болоод байна. Зүүн Хойт Азийн бүс нутагт үр дүнтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломжийг бид идэвхитэй эрмэлзэж ирсэн боловч төдийлөн үр дүнтэй бус байсаар байна.

Монгол Улсын хувьд байгалийн баялаг ихтэй, Зүүн Хойт Ази, Зүүн Өмнөд Азийн орнуудын дунд газар зүйн байршил сайтай, эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд харьцангуй хурдацтай байгаа зэрэг нь Зүүн Азийн дээд хэмжээний уулзалтын идэвхтэй гишүүн орон байх боломжийг олгож байгаа боловч өнөөг хүртэл тус байгууллагад гишүүнчлэлгүй байгаа нь тус байгууллагад элсэхэд чиглэгдсэн бидний идэвхитэй үйл ажиллагаа хангалттай бус байсантай холбоотой. Иймээс цаашдын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд бүс нутгийн байгууллагад гишүүнчлэлтэй болох, идэвхитэй гадаад бодлого явуулах замаар эдийн засаг, улс төрийн нөлөөгөө бүс нутгийн хүрээнд нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Ашигласан номзүй

1. Б.Балдоо “Монгол улс ба зүүн хойт ази” УБ. 2002
2. “Олон улсын эдийн засгийн харилцаа” УБ.2005
3. Л.Нямцэрэн “Шинэ эриний сорилт: Монголын хөгжлийн хүчин зүйлс” УБ. 2007
4. Б.Санжмятав “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт” УБ.2012
5. Б.Санжмятав “Олон улсын худалдаа” УБ.2013
6. МУИС, ОУХС-ийн эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. “Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол Улс” УБ.2011.
7. Үндэсний тагнуулын академи “Жижиг улсын аюулгүй байдал оноо, ирээдүй” УБ.2010
8. МУИС, Азийн судалгааны төв. “Зүүн хойт азийн төлөв байдал ба Монгол Улс” УБ.2002
9. ШУА, ОУСХ “Монгол Улс ба Зүүн хойт ази” УБ.2002
10. Я.Чимэгээ “Ази номхон далай бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо ба Монгол Улсын хувь нэмэр” УБ.2003
11. Д.Пүрэв ”Олон улсын эдийн засгийн харилцааны онол, практик, механизм” УБ.2003
12. Ази тив түүний салбар бүс нутгуудын хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо, хэтийн төлөв УБ.1997
13. Э.Гүргэмжав, М.Амартүвшин “Олон улсын худалдаа” УБ.2009

Интернет эх сурвалж

1. <http://economy.time.mn>
2. <http://mongoliaworld.net>
3. http://en.wikipedia.org/wiki/East_Asia_Summit
4. <http://www.theaustralian.com.au/national-affairs/foreign-affairs/east-asia-summit-to-negotiate-mega-trade-pact>
5. www.asean.org/asean/external-relations/east-asia-summit-eas